



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/141

Хэрлэн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу иргэн Лувсан-Ёндон овогтой Бат-Өлзийгийн эзэмшлийн Хэрлэн сумын 1 дүгээр баг /Хэрлэн/, Тэмүүжин гудамж байрлах, худалдаа, үйлчилгээний зориулалттай 670 м² газрыг иргэн Болд овогтой Тэмүлэнд 51 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.
2. Иргэн Б.Тэмүлэнгийн эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.
3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.
4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг Б.Тэмүлэнд үүрэг болгосугай.
5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2010 оны 57 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА